

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМУУДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ӨГӨХ САНАЛ

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Бизнесийн орчны ерөнхий үнэлгээг 2025 онд 3.5, 2030 онд 4.03 нэгжид хүргэхээр заасан. 2023 оны судалгаагаар бизнесийн орчны ерөнхий үнэлгээ 2.68 гэж үнэлэгдсэн нь цар тахлын өмнөх үеэс буурсан үзүүлэлт бөгөөд бизнес эрхлэгчдийн зүгээс эдийн засгийн салбаруудын бодлогын тогтвортой байдлыг хангах, хууль эрх зүйн зохицуулалтуудыг өөрчлөхдөө оролцогч талуудын нэгдсэн, нийтлэг саналыг идэвхтэй тусгадаг байх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, бизнесийн маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг сайжруулах, татварын жигд, таатай орчныг бүрдүүлэх, зээлийн хүүг бууруулж, зээлийн нөхцөлийг сайжруулах, хүний нөөцийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, бэлтгэх тогтолцоог шинэчлэх арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Мөн төр-хувийн хэвшлийн үр дүнтэй түншлэлийн хүрээнд эдийн засагт чухал ач холбогдолтой дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг цаг алдалгүй эхлүүлэх, төр бизнесийн салбарт хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байхыг чухалчилсан байна.

2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгахыг хүсэн бизнес эрхлэгчид болон бизнесийн зарим зөвлөл, холбоодоос ирүүлсэн саналуудыг нэгтгэн дараах байдлаар хүргүүлж байна.

1. Экспортыг дэмжих

2022 оны жилийн эцэст Монгол Улсын экспортын 93.8 хувийг уул уурхайн салбар, 6.2 хувийг уул уурхайн бус салбар, үүний дотор 0.2 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 4.4 хувийг мал аж ахуй бүрдүүлж байна. Энэ нь эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус экспортын нэр төрлийг нэмэгдүүлэх талаар дунд, урт хугацааны зорилтуудыг дэвшүүлж ирсэн ч өнөөг хүртэл бодитой үр дүнд хүрээгүйг харуулж байна.

Юуны өмнө экспортын хилийн доторх, хил дээрх, хилийн гаднах асуудал ба экспортын гол салбаруудын асуудлуудыг цогцоор нь багтаасан стратегийг төр хувийн хэвшил хамтран гаргаж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Түүнчлэн уул уурхайн бус экспортын боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, экспортын гол түүхий эдийн агуулахын тогтолцоо ба агуулахын санхүүжилт, хүртээмжтэй санхүүжилтийн зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх, үндэсний брэндингтэй уялдуулах шаардлагатай.

Экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд аж ахуйн нэгжүүд кластерийн зохион байгуулалтад орж экспортын эрэлт, зах зээлийн шаардлагыг хангах боломжтой. Дотоодын үйлдвэрлэгчдийн борлуулалтын чадавхыг сайжруулах, тогтолцоог боловсронгуй болгохын тулд экспортын эрэлтийг хангах нийлүүлэлтийн системийг бий болгох хэрэгтэй бөгөөд үүнд холбогдох төрийн байгууллагууд ба нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талуудын оролцоо, хамтын

ажиллагаа чухал юм. Мөн экспортын чанарын дэд бүтцийг хөгжүүлэх буюу шинжилгээ, сорилтын лабораторийн чадавхыг олон улсын жишигт хүргэх, шаардлагатай салбарын лабораториудыг байгуулах, малын эрүүл мэндийг сайжруулах ба бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх нь экспортыг дэмжих суурь асуудлууд юм.

Экспортын хилийн доторх, хил дээрх ба хилийн гаднах асуудлыг цогцоор нь багтаасан стратегийг төр хувийн хэвшил хамтран гаргаж хэрэгжүүлэх, экспортын батлан даалтын ба санхүүжилтийг тогтолцоог хөгжүүлэх, экспортын кластеруудыг дэмжин хөгжүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх тогтолцоог сайжруулах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай.

2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтыг дэмжих

Монгол улсын эдийн засгийг тэлж, өсөлтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын нэг чухал эх үүсвэр нь гадаадын шууд хөрөнгө оруулалт юм. Монгол Улс хэдийгээр хууль, зохицуулалтын хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалтад нээлттэй боловч бусад улс орнуудтай харьцуулахад гаднаас орж ирж буй хөрөнгө оруулалтын урсгал хангалтгүй байна. Монгол улсад оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО) 2011 онд 5.75, 2014 онд 1.99, 2017 онд 2.09, 2020 онд 2.56, 2022 онд 3.42 тэрбум ам.доллар байсан дүнтэй байна. 2023 онд 3-р улирлын байдлаар 1.87 тэрбум ам.долларын ГШХО Монгол Улсад орсон байна.

2011 оны байдлаар ГШХО-ын 78.2 хувь нь уул уурхай, олборлолт, 11.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 2.5 хувь нь санхүүгийн болон даатгалын салбарт тус тус орсон бол 2022 оны байдлаар 82.5 хувь нь уул уурхай, олборлолт, 4.6 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 4.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт орсон үзүүлэлттэй байна. Эндээс харахад 2012 оноос хойш гаднаас орж ирсэн нийт хөрөнгө оруулалтын 81 хувийг байгалийн нөөц баялаг эрэлхийлсэн хөрөнгө оруулалт эзэлж байгаа нь эдийн засгийн төрөлжилтийн хувьд тун хязгаарлагдмал байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд Монгол Улсад тулгарч буй нэг гол бэрхшээл нь улс төрийн ба бодлогын тогтворгүй байдал юм. Эдийн засгийн гол салбаруудын урт хугацааны бодлого, хөгжлийн зураглалуудын хуульчлан баталж, түүний хэрэгжилтийг тогтвортой, залгамж чанартайгаар хангуулах хэрэгтэй байна. Хэдийгээр 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад нөлөөлсөн гэх боловч гадаад этгээдийн хувь эзэмшил, үл хөдлөх хөрөнгө эзэмших эрх, суутган тооцох татвар, ажиллах зөвшөөрөл зэрэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг эргэн харж шинэчлэх, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж зохицуулалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах шаардлага байгаа юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудтай холбоотой үүссэн томоохон маргаануудыг нэг бүрчлэн шийдэх нь шинэ хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

Мөн компаниудын цэвэр ашгаасаа хийсэн шинээр ажлын байр бий болгосон, бодитой хөрөнгө оруулалтуудыг татварын бодлогоор дэмжих нь эдийн засгийн өсөлтийг бий болгоход бодитой хувь нэмэр болно.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шинэ хөрөнгө оруулалт татахын тулд хөрөнгө оруулалтын шинэ бодлого, стратегийг хувийн хэвшлийн оролцоотой боловсруулах, хуулийг шинэчлэх, хөрөнгө оруулалтын дэмжих талаар сурталчлах нь нэн тэргүүнд шаардлагатай байна. Мөн төрийн ба хувийн хэвшлийн байгууллагуудын үр дүнтэй, үялдаатай хамтын ажиллагаа гадаад хөрөнгө оруулалтыг татах нэг чухал хүчин зүйл юм.

3. Жижиг дунд бизнесийг дэмжих

Жижиг, дунд бизнес нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд онцгой үүргийг гүйцэтгэдэг. Дэлхийн банкны мэдээлснээр дэлхийн хэмжээнд ЖДБ нийт бизнесийн 90 орчим хувийг, ажил эрхлэлтийн 50 гаруй хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн албан ёсны бүртгэлтэй ЖДБ хөгжиж буй орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)- ий 40 хүртэлх хувийг бүрдүүлж байна. Иймд ЖДБ-ийг хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад онцгой хувь нэмэр оруулдаг тул олон орон ЖДБ-ийн хөгжлийг тэргүүлэх чиглэлээ болгосон байдаг. Монгол Улсын хувьд 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн 66.1% нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байгаа бөгөөд ДНБ-ий 5.5%-ийг бүрдүүлж, нийт барааны экспортын 2.4%, импортын 9.7%-ийг гүйцэтгэжээ.

Цах тахлын хамгийн их нөлөөлсөн сегмент нь ЖДБ бөгөөд судалгаагаар ЖДБ эрхлэгчдийн 77 хувь нь орлого буурсан, 72 хувь нь тээвэр, логистиктой холбоотойгоор түүхий эдийн хомсдол үүссэн, 53 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт буурсан, 44 хувь нь бэлэн мөнгөний хомсдол, 38 хувь зээлээ төлж чадахгүй хүндрэлд орсон, 35 хувь нь ажилчдынхаа цалинг өгч чадаагүй зэрэг асуудлууд бий болсон гэж гарсан. (*Sustainable Recovery Options for Mongolia's Micro, Small, and Medium-Sized Enterprises, 2020, ADB*)

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн 80 хувь нь бизнесээ эхлэх анхны санхүүжилтээ өөрийн хөрөнгө, найз нөхөд, гэр бүлийн хамтын хөрөнгөөр санхүүжүүлдэг ба харин бизнесээ өргөжүүлэх санхүүжилтийг ихэвчлэн банк болон ББСБ-ын зээлээр санхүүжүүлдэг байна. Үүнээс үзэхэд ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилтийн эх үүсвэрийн хомс байдал болон санхүүжилтийн өртөг буюу зээлийн хүүгийн дарамт хамгийн их хүндрэл учруулж байна. (*Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал, түүвэр судалгаа 2017, Монгол банк*)

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн “Бизнесийн Тогтвортой Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөрийн хүрээнд 2023 онд явуулсан судалгааны тайланд “Жижиг, дунд бизнесийн өрсөлдөх чадвар”-ын судалгаагаар ЖДБ-ийн өрсөлдөх чадвар компанийн түвшинд дундаж хэмжээнд байгаа бөгөөд өрсөлдөх чадварыг дэмжих бизнесийн экосистем дундаж түвшинд бүрдсэн ба цаашид хүчтэй түвшинд хүргэхийн тулд ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэж дүгнэсэн байна.

Жижиг дунд бизнесийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн сан, зээлийн батлан даалтын тогтолцоог оролцогч талуудтай хамтран сайжруулах, өртгийн сүлжээний зарим хэсэгт нь нэгдсэн байдлаар ажиллах систем, дэд бүтэц бий болгоход нь дэмжлэг үзүүлэх, жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

4. Хүний нөөцийн хангамжийг сайжруулах, гаднаас ажиллах хүч авахад дэмжлэг үзүүлэх

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн 2022 оны судалгаагаар 2023 оны ажиллах хүчний нийт эрэлтээр улсын хэмжээнд 84.6 мянган ажлын байр бий болох ба өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 6.0 мянга гаруй ажлын байр буюу 8.4 хувиар өсөж, хөдөлмөрийн зах зээлийн олон жилийн ерөнхий чиг хандлага хадгалагдах төлөвтэй гарсан. 2022 онд аж ахуйн нэгж байгууллагын 15.9 хувь нь шаардлагатай мэргэжилтэй ажилтан олдоогүйн улмаас төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй байна.

Монголын бизнесийн орчны судалгаагаар эдийн засгийн орчны дэд үзүүлэлт болох “Хүний нөөц, ажиллах хүч” гэсэн үзүүлэлт нь 2020 онд 2.91 гэж үнэлэгдэж байсан бол 2023 онд 2.68 болж буурсан байна. Үүний дотор ажилтны тогтвор суурьшил 2.83-аас 2.55, хүний нөөцийн олдоц 2.79-ээс 2.46 болж тус тус буурчээ. Монгол улс шиг хөгжиж байгаа, төрөөс сайн чанарын суурь боловсрол олгох боломж хязгаарлагдмал байгаа энэ үед мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвөөр дамжуулан ур чадварыг хөгжүүлэх, аж ахуйн нэгж, салбарын эрэлт хэрэгцээг хангах үндэсний хэмжээний үр дүнтэй хөтөлбөр, арга хэмжээ чухал бөгөөд үүнд хувийн хэвшлийн болон төлөөллийн байгууллагуудын оролцоо зайлшгүй хэрэгтэй байна. Хувийн хэвшлийн хувьд мэргэжлийн боловсролын сургуулийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийн шинэчлэлд хувь нэмэр оруулах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, ур чадвар олгох дадлага хийлгэх зэргээр хамтран ажиллана.

Түүнчлэн мэргэжилтэй ажиллах хүчний хомсдол нэгэнт бий болсон энэ үед гаднаас ажиллах хүч авах зайлшгүй шаардлага аж ахуйн нэгжүүдэд тулгарч байгаа бөгөөд ажиллах хүч авах зөвшөөрөл, квотын асуудал болон ажлын байрны төлбөр ихээхэн дарамтыг учруулж байна. Мэргэжилтэй ажиллах хүчний хангамжийг нэмэгдүүлэх, ялангуяа улирлын шинжтэй болон хөдөлмөр ихээр шаарддаг салбар, эдийн засагт ач холбогдолтой томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд гаднаас ажиллах хүч авахтай холбоотой үйл явцыг хялбаршуулах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх талаар анхаарч хойш тавихгүй шийдвэрлэх цаг нэгэнт болжээ.

Эдийн засгийн салбарын өсөлт, гадаад дотоод орчны өөрчлөлт, техник технологи, мэдээллийн технологийн хувьсал өөрчлөлтөд нийцэх ажиллах хүчнийг бэлтгэхэд дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын тогтолцоог шинэчилж өөрчлөх шаардлагатай байгаа бөгөөд мэргэжлийн боловсролд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гаднаас ажиллах хүч авах үйл явцыг хялбаршуулж, зардлыг бууруулахад төрийн бодлого зохицуулалт, дэмжлэг чухал байна.

5. Боловсруулах салбарыг дэмжих, хөгжүүлэх

Үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр 1995 оноос хойш Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх бодлогыг батлах тухай /1998 он/, Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай /2003/, 2009 оныг “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил” болгох тухай, “Үйлдвэржилтийн шинэ эрин үе” зарласныг дэмжих тухай /2012/, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /2015/, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль /2015 он/, “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр батлах тухай /2018/, Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай /2019 он/ зэрэг болон аж үйлдвэрийн тодорхой салбарын хууль тогтоомж, хөтөлбөр бодлогууд гарч байсан. Гэвч төрийн бодлогын залгамж халаа, хуулийг хэрэгжүүлэх төрийн институт тогтворгүй, хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр байхгүй зэргээс үр дүн, хэрэгжилт хангалтгүй явж ирсэн.

2023 онд боловсруулах үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 4.76 их наяд төгрөг болж тухайн оны үнээр тооцсон ДНБ-ий 6.9 хувийг эзэлсэн бөгөөд 48.6 хувийг хүнсний үйлдвэрлэл, 12 хувийг ундааны үйлдвэрлэл (согтууруулах ундаа орсон), 11 хувийг төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл тус тус эзэлж байна. Боловсруулах үйлдвэрлэл 1993 онд бодит ДНБ-ий 25.2 хувийг эзэлж байсан бол, 1998-2018 оны хооронд дунджаар 5.8-8.7 хувь, 2023 онд 8.1 хувь байна. Үүний дотор мал аж ахуйн гаралтай боловсруулах үйлдвэрлэл болох нэхмэлийн үйлдвэрлэл 2007 онд 0.4 хувь, 2017 онд 0.11 хувь, арьс арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2007 онд 0.03 хувь, 2017 онд 0.02 хувь байсан бөгөөд 2022 оны байдлаар энэ үзүүлэлтүүд 0.09 хувь, 0.03 хувь байгаагаас харахад ямар нэгэн ахиц гараагүй байна.

Аж үйлдвэр, түүний дотор боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг тогтолцоогоор нь авч үзэх, төрийн байгууллагуудын гаргаж байгаа бодлого, салбар хоорондын зохицуулалт, үйл ажиллагааг уялдуулах нэн шаардлагатай. Үүний дотор хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах болон стратегийн ач холбогдол бүхий нефть боловсруулах, зэс хайлуулах ба гангийн үйлдвэр боловсруулах, дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, үйлдвэрийг шинээр барих, өргөтгөхөд оруулж байгаа хөрөнгө оруулалтыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийн дэмжих үүднээс төрийн ба төрийн өмчит компаниудын худалдан авалтыг нэгдсэн, үр дүнтэй бодлого гаргаж хэрэгжүүлэхэд онцгойлон анхаарах хэрэгтэй.

6. Татварын цогц шинэчлэл хийх

Монголын бизнесийн орчны 2023 оны судалгаагаар татварын орчин 2020 оноос 0.12 нэгжээр буюу 5 хувиар буурч, 2.50 оноогоор дундаас доогуур үнэлэгджээ. Энэ судалгааны үр дүнгээс харахад бизнес эрхлэгчид бизнесийн орчныг сайжруулахад татварын таатай орчин бүрдүүлэх, тодруулбал татварын хувь хэмжээ, ачааллыг бууруулан нийтээрээ жигд татвар төлдөг байх, төлсөн татварын зарцуулалтыг үр ашигтай оновчтой байлгахад анхаарах шаардлагатай гэж үзсэн байна.

Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 88.2 хувийг татварын орлого бүрдүүлж байна. Татварын орлогын дүн 2023 онд 21.5 их наяд төгрөг болж өмнөх оноос 31.3 хувиар нэмэгдэхэд хөрөнгийн албан татвар 67%, орлогын албан татвар 52%, нийгмийн даатгалын орлого 30%, нэмэгдсэн өртгийн албан татвар 21% өссөн нь голчлон нөлөөлжээ.

2022 онд татварын орлого 15.6 их наяд төгрөгийг бизнес регистрийн санд бүртгэлтэй идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 81.5 мянган аж ахуйн нэгж бүрдүүлсэн нь дунджаар нэг аж ахуйн нэгжид 190 сая төгрөг оногдож байв. Харин 2023 онд татварын орлого 21.5 их наяд төгрөг болж өмнөх оноос 38 хувиар өссөн бол аж ахуйн нэгжийн тоо 85.2 мянга болж дөнгөж 5 хувиар өсжээ. Тодруулбал 2023 онд дунджаар нэг аж ахуйн нэгж 252 сая төгрөгийн татвар хураамж төлсөн нь өмнөх жилээс 32 хувиар өссөн ба нэг аж ахуйн нэгжийн төлсөн татварын дүн, ачаалал өссөн дүнтэй байна.

2023 онд Монгол улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 23.2 их наяд төгрөг болж өмнөх оноос 35.6 хувиар өссөн бол нийт зарлага цэвэр зээлийн дүн 22.5 их наяд төгрөг ба өмнөх оноос 4.3 их наяд төгрөг, 24 хувиар өсжээ. Улсын нэгдсэн төсвийн зарлагын дөнгөж 23 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байгаа бол 76 хувийг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөжээ. Энэ нь өмнөх жилүүдийн зарим тооцоо судалгаа багатай, үр ашиг багатай төсвийн зарцуулалтууд нь дараа дараагийн жилийн улсын төсөвт урсгал зардал хэлбэрээр дарамт болж, шинэ хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт хийх орон зайг хязгаарлаж байгааг анхаарах шаардлагатай байна.

Бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний эхэнд татварын ачааллыг бууруулах асуудал зүй ёсоор тавигдаж ирсэн. Татварын хувь, хэмжээг бууруулах, хууль, дагалдах журам зохицуулалтуудыг ойлгомжтой, хоорондоо уялдаатай, зөрчилгүй болгох, бодлогоор дэмжих салбаруудад татварын зөв хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх, татварын суурийг нэмэгдүүлэх, татвар төлөлт жигд, шударга байх, татварын хуулийн тодорхой заалтуудыг боловсронгуй болгох, холбогдох хуулийг өөрчлөхдөө оролцогч талуудтай хэлэлцэж, нэгдсэн саналуудыг нь тусгадаг байх зэрэг нь байнга хөндөгдөж байна.

Мөн татвар, шимтгэлийн орлогоос бүрддэг төрөл бүрийн сангуудын үйл ажиллагаа, сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалтад татвар, шимтгэл төлөгчид хяналт тавих боломжтой болгох, үр ашиггүй, зорилгоо хэрэгжүүлж чадахгүй байгаа сангуудыг татан буулгаж, дахин шинээр байгуулахгүй байх саналтай байна.

Татварын хууль, дүрэм журмуудыг хэрэгжилтийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийх замаар зохицуулалтыг боловсронгуй болгох, татварын суурийг нэмэгдүүлэх, төлсөн татварын зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах, татварын бодлогыг эдийн засгийн өсөлтийн хөшүүрэг болгон ашиглах гэх мэтчилэн татварын асуудлыг цогцоор авч үзэн шинэчлэл хийх саналтай байна.

7. Аж ахуйн нэгжүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн ачааллыг бууруулах

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 онд 356.3 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 23 хувиар, 2021 онд 853.9 тэрбум төгрөг 45.5 хувиар, 2022 онд 780.5 тэрбум төгрөг буюу 28.6 хувиар тус тус өссөн. 2023 оны байдлаар өмнөх онтой харьцуулахад 805.3 тэрбум төгрөг буюу 22.9 хувиар өссөн ба 2018 оны дүнгээс 2.27 дахин нэмэгдэж 4.32 их наяд төгрөг болсон байна. Харин нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо 2018 онд 8.1 хувиар буурсан бөгөөд 2021 онд 0.6, 2022 онд 5 хувиар тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого нийгмийн даатгалын шимтэл төлөгчдийн тооноос давсан өндөр өсөлтийг үзүүлсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өсөлт болон цалингийн өсөлттэй холбоотой харагдаж байна. Энэ нь ажил олгогчдод хамгийн их дарамтыг бий болгож байгаа учраас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын хувь хэмжээг бууруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөх дээд хязгаарыг ажил олгогчийн хувьд мөн мөрддөг болгох шаардлага байна.

Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, нийгмийн даатгалын санг зөв удирдах замаар нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулж аж ахуйн нэгжүүдэд ирж байгаа ачааллыг бууруулах шаардлагатай байна.

8. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд томоохон төслүүдийг хэрэгжүүлэх

Монгол улсын эдийн засгийг тэлэхийн тулд эдийн засагт том ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг бодлогоор дэмжин эхлүүлэх, хэрэгжүүлэх нь чухал байна.

Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 онд батлагдан 2024 оноос хэрэгжиж эхлээд байна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн санхүүжилтийн санаачилгыг дэмжих шаардлагатай юм. Улс орны хөгжлийг түргэтгэх хөгжлийн төслүүдийг хувийн хэвшил гүйцэтгэх боломжийг олгох нь Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Тухайлбал хилийн боомтууд (Ханги, Бичигт, Хавирга, Шивээхүрэн, Булган) ба эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтыг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой юм. Эдийн засгийн коридор байгуулах гурван талт хэлэлцээрийн хүрээнд тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах шаардлага тулгарч байна.

Хэдийгээр хууль эрх зүйн орчны суурь тавигдсан ч томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой бодлого зохицуулалтын тогтвортой

орчныг бүрдүүлэх нь ихээхэн чухал байна. Тухайлбал, газар ашиглах эзэмших, зөвшөөрөл авах, ажиллах хүч нийлүүлэх, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, орон нутагт гардаг асуудлуудыг нэгдсэн байдлаар зохицуулах болон салбарын хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох асуудлыг тогтолцоогоор нь авч үзэх нь урт хугацаанд үр нөлөөгөө өгнө.

Хувийн хэвшлийн том төслүүдийг амжилттай эхлүүлэх, хэрэгжүүлэх хууль эрх зүй болон бодлогын тогтвортой орчныг бий болгох, том төслүүдийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, төслүүдийг хөрөнгө оруулагчдад сурталчлан таниулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгтэй.

9. Тээвэр логистикийн салбарын хөгжлийг дэмжих

ДНБ-д тээврийн салбарын эзлэх хувь 2009 онд хамгийн өндөр буюу 8.3 хувь байсан ба тасралтгүй буурсаар 2021 онд хамгийн бага буюу 3.7 хувьд хүрчээ. Харин 2022 оны тээврийн салбарын ДНБ-д эзлэх хувь 4.7 хувь болж өмнөх оноос 1.0 нэгж хувиар өсөж, 2018 онтой ижил түвшинд, 2019 онтой харьцуулахад 0.2 нэгж хувиар өссөн байна. Харин тээвэр, агуулахын салбарт 2022 онд гадаадын болон дотоодын эх үүсвэрээс 246.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оноос 90.7 (26.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Тээвэр, агуулахын салбарт хийсэн хөрөнгө оруулалт нь нийт хөрөнгө оруулалтын 1.4 хувийг эзэлж байна.

Мөн 2019 он буюу Ковидын өмнөх үед Тяньжин боомтод хуримтлагдсан чингэлгийн тоо 2500-2800 ба Тяньжин боомтод чингэлэг хүлээгдэх хугацаа 10 хоног байсан бол 2022 онд чингэлгийн тоо 8000 хүрч, хүлээгдэх хугацаа 90 хоног болсон. Мөн чингэлгийг Эрээн – Улаанбаатар хүргэх автотээврийн зардал дунджаар 2019 онд 1400 орчим ам.доллар байсан бол 2022 онд 11 мянган ам.доллар болж нэмэгдсэн байна. Харин 2023 оны 9 сарын байдлаар Тяньжин боомтод 4000 - 4400 чингэлэг хуримтлагдан, 60-65 хоног хүлээгдэж байгаа ба Эрээн – Улаанбаатар хүргэх автотээврийн зардал 1600 орчим ам.доллар байна.

Орчин үеийн олон улсын стандарт шаардлагыг хангахуйц нэгдсэн логистикийн терминал байхгүйгээс ачаа бараа хүлээн авах тээвэр логистикийн үйл ажиллагаа нь Амгалан, УБ, Толгойт өртөөдөөр салж, тээвэр зуучийн 11 ачаа тээврийн терминал болон нийт 362 гаруй салбар замуудаар түгээгдэж байгаа нь ачилт буулгалтын зардал өндөр байх, вагоны эргэлтийн хугацаа уртсах зэрэг шалтгаан болж байна.

Юуны өмнө тээвэр, логистикийн салбарын урт хугацааны нэгдсэн бодлого, чиглэлийг төр хувийн хэвшил хамтран гаргах, түүнчлэн дотоодын тээвэр логистикийн сүлжээг сайжруулах арга хэмжээнүүдийг оролцогч талууд хамтдаа шаардлагатай гэж үзэж байна. Тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн зүгээс хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, тээвэр логистикийн өртгийг бууруулах болон Хятад– Монгол-Орос гурван улсын тээврийн коридорын үр ашгийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах чиглэлээр дараах саналтай байна. Үүнд:

- Үндсэн тээврийн хуулиудаар салбарыг зохицуулах боломжгүй байгаа тул Тээвэр зуучлалын тухай хуулийг боловсруулж батлах, бусад хууль эрх зүйн актуудад тусгах
- Тээвэр логистикийн салбарын татварын бодлогыг тодорхой болгох, транзит ачаанд НӨАТ ногдуулахгүй байх
- Эдийн засгийн салбарын ангилал дахь тээвэр зуучийн үйл ажиллагааг тээврийн үндсэн үйл ажиллагаанд оруулах
- Дотоодын дэд бүтцийг сайжруулах, тээврийн хэрэгслийн эргэлтийн хугацааг багасгах
- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн транзитын эрх чөлөөтэй холбоотой заалтуудын биелэлтийг хөрш орнуудын үндэсний хорооноос шаардах
- Монголд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд хөрш орнуудад тээвэр хийх боломжийг бүрдүүлж, холбогдох талуудтай зөвшилцөх
- Төмөр замын тарифыг тогтвортой хадгалах
- Төмөр замын транзит тээврийн тарифын ачааны хэмжээнээс хамаарсан хөнгөлөлтийг болиулах
- Автын транзит тээвэрт гурван талт хэлэлцээр хийж, Монгол Улсын нутаг дэвсгэрт дамжин өнгөрөх үед гадны тээвэрлэгч нартай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

Тээвэр зохион байгуулах зуучлах ажил нь аливаа улсын стратегийн салбар байдаг бөгөөд ялангуяа хоёр том хөрштэй манай улсын хувьд анхаарал тавьж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үндэсний тээврийн салбарыг хамгаалах чиглэлээр нэгдсэн бодлого боловсруулах шаардлагатай байна.

10. Эрчим хүчний салбарын бодлого, урт хугацааны төлөвлөлтийг шинэчлэн гаргах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг санаачилгыг дэмжих

Монгол улсын эрчим хүчний хэрэглээ 2022 онд 2010 онтой харьцуулахад 139.8 хувь, түгээлтийн болон шугамын алдагдал 115.9 хувь тус тус өссөн бол үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч 86.3 хувь, импортын цахилгаан эрчим хүч 6.3 дахин буюу 629.7 хувь тус тус өссөн дүнтэй байна.

2010 онд нийт хуваарилагдсан эрчим хүчний 5.7 хувийг импортолдог байсан бол 2022 онд 20.8 хувийг нь импортын эрчим хүч эзэлж байгаа нь шинэ цахилгаан станцын төслүүдийг нэн түрүүнд хэрэгжүүлэх явдал зайлшгүй байгааг илтгэж байна. Сүүлийн жилүүдэд өвлийн улиралд эрчим хүчний салбар ачааллаа даахгүйд хүрч, эрчим хүчний эх үүсвэрийн дутагдлыг эрчим хүчний хэмнэлтээр нөхөх болсон.

2015 онд Монгол Улсын Их Хурлын чуулганаар “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”-ыг баталснаас хойш Монгол улсын хувьд төдийгүй олон улсын түвшинд эрчим хүчний аюулгүй байдал болон тогтвортой байдлын талаар гарч байгаа өөрчлөлтөд салбарын бодлого, төлөвлөлтийг нийцүүлэх хэрэгтэй. Иймд эрчим хүчний салбарыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө буюу Мастер төлөвлөгөөг Монгол Улсын өнөөгийн хийгээд ирээдүйн бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж шинэчлэн батлах шаардлагатай. Энэ салбарын аж ахуйн нэгжүүдийн зүгээс өмнөх намуудын болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт

оруулж байсан зарим заалтуудыг шинэчлэн томьёолж оруулах, шинээр нэмэх тодорхой саналуудыг ирүүлсэн. Үүнд:

- Улиастай-Дөргөн-Мянгадын чиглэлд 220кВ-ын хос хэлхээт 380км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих судалгаа хийхийн оронд цаашид Говь-Алтай аймагт аж үйлдвэрийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Алтай-Дөргөн-Мянгадын чиглэлд 220кВ-ын хос хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам (423 км орчим), дэд станц барих судалгаа хийх
- Хотын дулаан, цахилгааны найдвартай эх үүсвэрийг бий болгох зорилгоор 5 дугаар дулааны цахилгаан станцыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулах төслийг хэрэгжүүлэх
- Говийн бүсэд эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг барьж байгуулан экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- БНХАУ-тай хил дамнасан эрчим хүчний арилжаа хийх хууль эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлж дэд бүтцийг хэрхэн бүтээн байгуулах асуудал дээр БНХАУ-тай тохиролцож дэд бүтцийг бүтээн байгуулалтыг хэсэгчлэн эхлүүлэх
- Зүүн Хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгад идэвхтэй оролцож, эрчим хүчний хил дамнасан арилжаа хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж сэргээгдэх эрчим хүчний их чадлын цогцолбор барьж байгуулах ажлыг эхлүүлэх
- Цахилгаан тээврийн хэрэгслийг бодлогоор дэмжиж, сэргээгдэх эрчим хүч ашиглан цэнэглэх шугам сүлжээ, дэд станцуудыг байгуулах

Монгол Улсын эрчим хүчний салбарын цаашдын бодлого, түүний дотор ногоон эрчим хүч рүү шилжих бодлогыг тодорхойлж, олон улсын байгууллагуудаас техникийн туслалцааны хүрээнд хувийн хэвшлийн оролцоотой эрчим хүчний урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг гаргах, энэ салбарын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын санаачилгыг дэмжих нь зүйтэй.

11. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих

Монгол Улсын эрчим нэгдсэн системд 2022 оны байдлаар 3 салхин цахилгаан станц, 8 нарны цахилгаан станц, 7 усан цахилгаан станц эрчим хүч үйлдвэрлэж байгаа бөгөөд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 748.9 сая кВт.ц болж дотоодын нийт үйлдвэрлэлийн 9.2 хувийг эзэлсэн ба 2014 оноос 2.9 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Мөн Монгол Улсад суурилагдсан эрчим хүчний үүсгүүрүүдийн хүчин чадлын 18 хувийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүд эзэлж байна.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор дэлхий нийт сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг эрчимтэй нэмэгдүүлж байгаа ба Олон улсын эрчим хүчний агентлагаас 2028 онд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэл дэлхийн нийт эрчим хүч үйлдвэрлэлийн 40 гаруй хувийг эзэлнэ хэмээн мэдээлсэн.

Монгол улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжих бодлого гарган тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний үр дүнд аж ахуйн нэгжүүдийн зүгээс энэ салбарт тодорхой хөрөнгө оруулалт оруулан үйлдвэрлэл нэмэгдсэн дүнтэй байна. Гэхдээ зарим үед бодлого тогтворгүй байх, өөрчлөгдөх

байдал гардаг. Салбарын аж ахуйн нэгжүүдийн зүгээс өмнөх намуудын болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулж байсан зарим заалтуудыг шинэчлэн томьёолж оруулах, шинээр нэмэх тодорхой саналуудыг ирүүлсэн. Үүнд:

- Эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгож, сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчний хангамжид эзлэх хувь хэмжээг 20 хувьд хүргэх
- Сэргээгдэх эрчим хүчний нөөц ашиглан цахилгаан, дулаан үйлдвэрлэх, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах хаягдлыг багасгах ногоон үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг дэмжих
- Сэргээгдэх эрчим хүчний төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг босгосон оронтой хүчин төгөлдөр давхар татварын гэрээ үйлчилж байгаа эсэхийг үл харгалзан хүүгийн орлогод ногдох албан татварыг 5-10 хувь хүртэл бууруулах
- Сэргээгдэх эрчим хүчний нөөцийг нь үнэлж баталгаажуулсан талбаруудад сэргээгдэх эрчим хүчний станц барьж байгуулан Оюутолгойн уурхайг цэвэр цахилгаанаар хангах
- Цахилгаан эрчим хүчийг сэргээгдэх эрчим хүчний нөөц ашиглан үйлдвэрлэх бодлогыг барьж нэн тэргүүн ээлжид БНХАУ-д экспортлох төсөл хэрэгжүүлэх хууль эрхзүйн орчин нөхцөлийг бүрдүүлж, төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх
- Аж ахуйн нэгжүүд цэвэр эрчим хүчийг өөрсдийн сонголтоор худалдаж авах боломжийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгжид зориулсан ногоон тарифыг баталж экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулах
- Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд “Эрчим хүч үйлдвэрлэгч иргэн” хөдөлгөөнийг гэр хороололд өрнүүлж, иргэд хашаандаа нар салхины сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн хэрэглэхээс гадна илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний сүлжээнд худалдан борлуулахыг дэмжих

Сэргээгдэх эрчим хүчний салбарыг дэмжих бодлого тогтвортой байх, үүний дотор татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх замаар энэ салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн урт хугацаандаа цэвэр эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх нь чухал алхам болно.

12. Төрийн албан хаагчдын орон тоог бууруулах

Төрийн албан хаагчдын тооны өсөлт 2022 онд 2010 онтой харьцуулахад 155.7 мянгаас 225.2 мянга болж 69.5 мянгаар буюу 44.9 хувиар нэмэгджээ. Түүний дотор төрийн улс төрийн албаны тоо 29.3 хувиар, төрийн захиргааны албаны тоо 44.1 хувиар, төрийн тусгай алба 68.3 хувиар, төрийн үйлчилгээний алба 39,1 хувиар тус тус өссөн байна.

Мөн төрийн албан хаагчдын тооны өөрчлөлтийг сонгуулийн жилүүдэд авч үзэхэд сонгуулийн жил буюу сонгуулийн дараа жилд нь огцом нэмэгдэж ирсэн байна. Тухайлбал төрийн улс төрийн албаны тоо өмнөх жилтэй нь харьцуулахад 2013 онд 186 буюу 6.6 хувь, 2017 онд 398 буюу 13.1 хувь, 2021 онд 546 буюу 15.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Эдийн засгийн нөхцөл байдал хүнд, улсын төсвийн алдагдал жилээс жилд өсөж байгаа, хүний нөөцийн хомсдолтой байгаа энэ үед улам бүр томорч буй төрийн бүтэц, орон тоог зохистой хэмжээнд хүртэл бууруулах зайлшгүй хэрэгтэй.

Төрийн үйлчилгээг цахимжуулах, төрийн байгууллагуудад менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх, төрийн албан хаагчдын бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулах замаар төрийн албаны тоог бууруулах, цаашид нэмэгдүүлэхгүй байх нь чухал юм.

13.Төрийн өмчит аж ахуйн нэгжийн оролцох бизнесийн салбар, хүрээг тогтоож, засаглалыг нь сайжруулах

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын тоо 2019 онд 370 байсан бол 2022 онд 439 болж 11 хувиар өсөж, 2010-2022 онуудад төрийн өмчит компаниудын нийт хөрөнгө 11.7 дахин өссөн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны тайлангаас харахад 2021 оны эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 89 хуулийн этгээд 53.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 123 хувьтай тэнцэх хөрөнгө эзэмшиж үйл ажиллагаа явуулж, эдгээрээс 44 нь 240.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд 18.1 их наяд төгрөг буюу ДНБ-ий 42 хувьтай тэнцэх хэмжээний өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

МҮХАҮТ-аас 2020 онд санхүүгийн мэдээлэл нь нийтэд ил төрийн өмчит ба төрийн оролцоотой 80 аж ахуйн нэгжийн 2019 оны жилийн эцсийн борлуулалтын орлого, өр төлбөр болон ашиг алдагдлыг авч үзсэн. Эдгээр аж ахуйн нэгжийн 32.1 хувь нь алдагдалтай, 43.4 хувь нь 5 хүртэл, 10.5 хувь нь 5-20, 18.4 хувь 20-аас дээш хувийн ашигтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан аж ахуйн нэгжүүдийг авч үзвэл, 43 төрийн өмчит хувьцаат компанийн 11 нь буюу 25.6 хувь, 14 хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 8 нь буюу 57.1 хувь, 20 төрийн өмчит үйлдвэрийн газрын 7 нь буюу 35 хувь нь алдагдалтай ажиллажээ. 2019 оны байдлаар эдгээр аж ахуйн нэгжүүдийн 12 нь жилийн ашгаасаа 30-100 дахин, 13 нь 100 дахинаас илүү өр төлбөртэй гарсан байна.

Төрийн өмчит компаниудын оролцох салбар, хүрээг тодорхой болгон олон нийтийн оролцоог хангаж засаглалыг сайжруулах, ил тод болгох, шаардлагагүй компаниудаа хувьчлах, татан буулгах, бусад салбарт хувийн хэвшилтэй өрсөлддөггүй байх нь эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Эдийн засаг дах төрийн оролцоог бууруулахтай холбоотой өөр нэг асуудал нь нийтийн төмөр замын салбарт хувийн хэвшлийн оролцоог хангалттай нээх явдал юм. Нийтэд төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлэх бизнесийн салбарт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой цөөн хэдэн хуулийн этгээд монопол, давамгайл байдалтайгаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хуулиар бүрдүүлсэн нь тухайн салбарт өрсөлдөөнийг хязгаарлаж, төмөр замын тээврийн үйлчилгээний үнэ тариф зах зээл, өрсөлдөөний зарчмаар тогтох боломжгүй байдлыг бий болгож байна. Иймд энэ салбарыг бүрэн либералчлах, нийтийн төмөр замын салбарт гадаад дотоодын хувийн хэвшлийн оролцоог бий болгох, нийтийн зориулалттай төмөр замын суурь бүтцийн өмчлөгч нь өмчийн аль ч

төрөл, хэлбэртэй байж болохыг хуулиар зөвшөөрөх нь Монгол Улсын төмөр замын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын жишиг стандартаар хөгжүүлэх, нийтийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, арчлах, ашиглахтай холбоотой нүсэр зардлыг төрийн нуруунаас авч хаях, зах зээлийн зарчмаар нь хөгжүүлэх боломжийг нээнэ.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглал, удирдлагын тогтолцоонд эрс шинэчлэл хийх, үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангах, чадварлаг менежментийн багаар удирдуулах, төрийн өмчийг хувьчлах замаар эдгээр аж ахуйн нэгжүүдийн бүтээмж, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

14. Авлига, хүнд суртлын эсрэг төр ба хувийн хэвшил хамтдаа тэмцэх

“Транспэрэнси интернэшнл” байгууллагын “Авлигын төсөөллийн индекс 2022” тайлангаас харахад Монгол улс судалгаанд оролцсон 180 орноос 116 дугаарт жагссан нь 4 жилийн өмнөхөөс 23 байр ухарсан байдалтай байна.

МҮХАҮТ-аас гаргасан Хүнд суртлын индекс 2021 судалгаагаар хүнд суртлын ерөнхий үнэлгээг 5 үзүүлэлтээр тодорхойлоход төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын үнэлгээ бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад сайн, харин төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо муу байна. Нарийвчилсан үзүүлэлтүүдээс үйлчилгээ авахад зарцуулж буй хугацаа хамгийн их хүндрэл үүсгэж байгаа бол үйлчилгээтэй холбогдох мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал, албан зардлын хэмжээ дунджаас дээгүүр илүү сайн үнэлгээтэй байв. 2021 онд хүнд суртлын индексийн үнэлгээ 2.72 үнэлгээтэй байгаа ба энэ нь 2018 оноос 0.18 нэгжээр багассан ба бизнес эрхлэгчид цар тахлын өмнөх үетэй харьцуулахад төрийн үйлчилгээ авахад хүнд суртал ихэссэн гэж үзжээ.

Төрийн үйлчилгээний үндсэн 4 төрлөөс зөвшөөрлийн үйлчилгээ хамгийн бага үнэлгээтэй буюу хамгийн их хүнд сурталтай байна. Бизнес эрхлэгчид төрийн нэг үйлчилгээ авахдаа дунджаар 6 баримт бичиг бүрдүүлж, 3 албан хаагчтай харьцаж, 13 хоног зарцуулж, 360 мянган төгрөгийн албан зардал гаргаж байна. Харин нийт судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 45 хувь нь үйлчилгээ авахдаа албан бус зардал гаргасан ба нэг үйлчилгээ авахад дунджаар 219 мянган төгрөг төлсөн гэжээ.

Бизнесийнхний хувьд тулгамдсан асуудал болох авилгаас ангид байх, хүнд суртлын бууруулах нөхцөлийг бүрдүүлэх зөв тогтолцоог бий болгох, өөрөөр хэлбэл төрийн байгууллагуудын ил тод, шилэн байх явдлыг хангах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатай бөгөөд үүний төлөө төр хувийн хэвшил хамтран ажиллах нь илүү үр дүнтэй байх болно.